



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ 10 ДУГААР САРД
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.

Төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасаг гэсэн 2 тасагтайгаар тайлант хугацаанд ажлын чиг үүрэг, хуваарийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

- 1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.3 Гэрээт ажилчдын ахисан түвшний боловсролыг дэмжих ажлын хүрээнд

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

- 2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.2 БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.3 Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд
- 2.4 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

- 3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд
- 3.2 Сургалт, судалгааны ажлын хүрээнд
- 3.3 Бусад дотоод ажлын хүрээнд

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2023 оны 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 416 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн алба болон ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын “Самсунг” даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардал, гэнэтийн ослын даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал, авч чадаагүй цалин хөлс зэрэг нийт 120,602,100 вон /нэг зуун хорин сая зургаан зуун хоёр мянга нэг зуу/-ыг Монгол Улсын иргэдэд олгууллаа. Тухайлбал, нутаг буцах замын зардал 2,500,000 вон, Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин хэлбэрээр 35,946,900 вон, бусад төрлийн визтэй иргэдэд үйлдвэрлэлийн ослын даатгал 74,575,200 вон, хууль бусаар ажилладаг иргэдийн авч чадаагүй цалин хөлс 8,080,000 воныг ажил олгогчоос тус тус гаргуулан өргөдөл гаргагчдад олгуулсан.

1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд:

- Төвийн цахим хуудсаар ирж буй өргөдлийг төрөлжүүлэн хүлээн авч, 24 иргэний санал, хүсэлтэд холбогдох зөвлөгөө мэдээллийг өгөв.

1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд:

- Иргэн Х.Т-ийн нүдний эмчилгээ дуусаж тахир дутуугийн /хөдөлмөрийн чадвар алдалт/ зэрэг тогтоолгоход 8-1-р зэрэг буюу нэг нүдний хараагаа алдах болон хараа нь 0,02 хүртэл буурах гэсэн онош тогтоон нийт ажлын 495 хоног гэж үзэж 1 өдрийн цалинг 131,400 вон гэж тооцож тахир дутуугийн тэтгэмж 65,043,000 воныг олгуулсан. Одоогоор 3-6 сард нэг удаа эмнэлэгт үзүүлж шаардлагатай үзлэг, эмчилгээ хийлгэх заалттай байгаа ба энэ эмчилгээг 2 жилийн турш хийлгэх юм. Мөн хараа нь илүү муудах буюу ямар нэг асуудал үүсвэл үйлдвэрийн ослын даатгалд дахин өргөдөл гаргах, үзлэг, эмчилгээ авсан өдрийн ажилгүйдлийн цалин болон эмчилгээний зардлаа гаргуулах боломжтой. Оршин суух визийг мөн эмчилгээний заалтын дагуу сунгуулан ажиллаж байна.

1.4 Ахисан түвшнийг дэмжих ажлын хүрээнд

- Е-9 статусаас Е-7-4 рүү визний ангиллаа солиулж ахисан түвшинд хүрэх хүсэлтэй иргэдийг бүртгэлийн санд оруулж, холбогдох сургалтад бүртгүүлэх, бусад зөвлөгөө мэдээлэл өгч, оноог тооцоолж өгөв.

- К-пойнт Е-7-4 ур чадвартай ажиллах хүчний оноот системийн виз рүү шилжих бүртгэлийн мэдээллийг оруулж, 136 хөдөлмөрийн гэрээт иргэд рүү утсаар холбогдон мэдээлэл зөвлөгөө өгөв.

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 21 иргэнийг шинээр хамруулан <https://app.ndaatgal.mn:811/nd> web программд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 21, гэрээний хугацаа сунгасан 25, ажлын байраа сольсон, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 10 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

2.2 БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

10 дугаар сарын 31-ний байдлаар сайн дурын даатгалд нийт 1,012 даатгуулагчийн бүртгэл хийгдэж, холбогдох хувийн хэргийг хөтлөн <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/> программд мэдээллийг тогтмол шинэчлэн, хяналт тавин ажиллав.

Тайлант хугацаанд 40 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулж, гэрээ байгуулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 50 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов. Мөн 2023 оны 09 дүгээр сарын 30-наар гэрээ дуусгавар болсон даатгуулагч нарын гэрээг сунгаж ажиллав.

2.3 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд

НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 тушаалаар тус тасгийн 2023 оны орлогын төлөвлөгөө 3,347,614,600.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 278,967,883.33 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 43,450,500.00 вон, сайн дурын даатгалын шимтгэл 51,452,320.00 вон, нийт 94,902,820 вон буюу 242,951,219.20 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 10 дугаар сарын орлогын төлөвлөгөөг 87 хувийн гүйцэтгэлтэй биелүүлэв.

Тэтгэврийн даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/ndweb/> программ, сайн дурын даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/sdkorea> программд даатгуулагчдын мэдээлэл, гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог хянан, төлөлт хийлгэж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 410 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, 744 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын байдлаар харуулбал:

*/2023.10.31-ний өдрөөр, ханш 2.56/
Хүснэгт-1*

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Албан журмын даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гаригийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
10	278,967,883.33	43,450,500.00	111,233,280.00	51,452,320.00	131,717,939.20	94,902,820.00	242,951,219.20	87	2.56

2.4. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (E-9, H-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 193 дугаар ээлжийн 4 иргэний материал НДЕГ-аас ирснийг БНСУ-ын ҮТА-д илгээсэн ба өмнө нь ирсэн 190-192 дугаар ээлжийн хариуг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд

- Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 806, үүнээс 776 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 30 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

- 10 дугаар сарын 29-нд НДЕГ-аас уламжлал болгон зохион байгуулдаг хилийн чанадад суугаа Монгол Улсын иргэдэд “Нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгалд хамрагдах нь” сэдэвт цахим сургалтад “БНСУ дахь Нийгмийн даатгалын үйлчилгээ” сэдвээр иргэд, даатгуулагчдад танилцуулга хийж, сонирхсон асуултад хариулан оролцов.
- Төвийн үйл ажиллагаа, мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр төвийн цахим хуудсанд 7 мэдээ, төвийн нийтийн цахим хуудсанд 12 мэдээ мэдээлэл оруулан ажиллав.

3.2 Сургалт, судалгааны ажлын хүрээнд

- БНСУ-ын Хүний эрхийн зөвлөлөөс зохион байгуулсан E-9 визтэй хөдөлмөрийн гэрээт иргэдэд зориулсан дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээнд оролцов. Төслийн хөтөлбөр нь Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын хураамж болон мэргэжлийн сургалтад хамрагдсан бол төлбөрийн буцаан олголт олгох, зэрэг гэрээт ажилчдад үр өгөөжтэй хөтөлбөр юм.
- БНСУ-д 2023 оны 10 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 26 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав. Иргэдэд:
 - ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
 - Солонгос улсын хууль, дүрэм, журам
 - Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
 - Үйлдвэрийн осол, үйлдвэрийн ослын даатгал, ХАБЭ, ослоос урьдчилан сэргийлэх
 - Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
 - Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар
 - Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар
 - Нийгмийн даатгал гэсэн сэдвээр гэрээт иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч асуусан асуултад хариулав.
- 2023 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Гёнсан аймагт зохион байгуулагдсан “Гэрээний залуусын нэгдэл ТББ”-аас зохион байгуулсан сагсан бөмбөгийн тэмцээний үеэр Гёнсан аймагт явуулын үйлчилгээгээр ажиллаж нийт 100 орчим иргэнд төвийн танилцуулга болон гарын авлага тарааж, 11 иргэнд цалин хөлсний маргаан, үйлдвэрийн ослын даатгал, үйлдвэрийн 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцахтай холбоотой мэдээ, мэдээлэл, ахисан түвшин буюу ур чадвартай ажиллах виз /E-7-4/-ний талаар, бусад холбогдох мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллав.

3.3 Бусад дотоод ажлын хүрээнд

- Төрийн албаны зөвлөлийн Пүрэв гарагийн ээлжит “7:4:10” цахим сургалтад 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр “Төрийн албан хаагч ба дипломат ёслол”, 10 дугаар сарын 26-ны өдөр “Work life balance schedule” сэдвээр тус тус төвийн албан хаагчид хамрагдав.
- Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 12 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг илгээв. Мөн нийгмийн даатгалын лавлагаа мэдээлэл шалгуулах хүсэлт гаргасан 14 даатгуулагчийн хүсэлтээр мэдээллийг гаргаж, даатгуулагчдад хүргүүлэв.
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 5 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгөв.
- Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкин дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын СБГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэв. Мөн 10 даатгуулагчаас ирсэн өргөдлийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэв.
- 2023 оны 09 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, НДЕГ, ХНХЯ-д хүргүүлэв.
- 2023 оны 10 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд НДЕГ-ын Тамгын газрын дарга Б.Батсүх тус тасагт албан томилолтоор ажилласан. Уг ажлын хүрээнд Тамгын газрын дарга Б.Батсүх тус тасгийн үйл ажиллагаатай танилцан, тулгарч буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлуудын хүрээнд харилцан санал солилцов. Мөн Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд сургалт зохион байгуулж, шинээр батлагдан гарсан хууль тогтоомжуудын талаар тайлбар мэдээлэл өгөв. Тасгийн үйл ажиллагааг сайжруулах талаар мэдээлэл, аргазүйн зөвлөгөө өгөв.
- Сөүл хотын Жунбугийн цагдаагийн газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тараах материалыг тус улсад оршин суугаа монгол иргэдэд түгээв.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ТАСГИЙН САР ТУТМЫН ТООН МЭДЭЭ
/2023 оны 10 дугаар сар/**

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	120,602,100 вон
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	416